



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/35

Хатан суудал

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/77 дугаар тушаал, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.5, 9.8 дахь хэсэг, Улсын онцгой комиссын 2 дугаар тогтоол зэргийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт байгаа үхэр сүргийг шүлхийн вакцинд хамруулах ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасаг, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг хуваарийн дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулахыг аж ахуйн нэгжүүдийн малын эмч нарт үүрэг болгосугай..

3.Дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Н.Цэрэндолгор)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642101383